



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР  
ТӨРИЙН БҮТЭЭМЖИЙН ҮНДЭСНИЙ ХОРООНЫ  
ТОГТООЛ

2023 оны 03 сарын 13 өдөр

Дугаар 02.

Улаанбаатар хот

**Нэгдсэн удирдлагын баг, Ажлын хэсэг  
байгуулах тухай**

Засгийн газрын 2022 оны 350 дугаар тогтоол, “Төрийн бүтээмжийн Үндэсний хорооны ажиллах журам”-ын 2.7-д заасныг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний төсөвлөлт, гүйцэтгэл, хяналт-шинжилгээ, үнэлгээ, тайлагналын үйл ажиллагаанд үр дүн, үр нөлөөнд сууриссан, нэгдсэн цахим удирдлагыг нэвтрүүлэн уялдуулах үүрэг бүхий Ажлын хэсгүүдийг нэгдсэн удирдлага, арга зүйгээр хангаж, үйл ажиллагааг нь уялдуулан зохион байгуулах чиг үүрэг бүхий Нэгдсэн удирдлагын багийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай:

Багийн ахлагч:

Монгол Улсын Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд

Гишүүд:

Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын дарга;

Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга;

Цахим хөгжил, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн дарга;

Ерөнхий сайдын хөгжлийн бодлого, төлөвлөлт, засаглалын асуудал хариусан зөвлөх;

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын зөвлөх;

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Засгийн газрын хүний нөөцийн газрын дарга;

Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын Тандалт судалгааны багийн ахлах судлаач;

Эдийн засаг, хөгжлийн яамны Хөгжлийн нэгдсэн бодлогын газрын дарга;

Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга;

Төрийн бүтээмжийн Үндэсний Хорооны Ажлын албаны дарга;

НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн төслийн зөвлөх (зөвшилцсөнөөр);

НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн төслийн зөвлөх (зөвшилцсөнөөр);

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Засгийн газрын хүний нөөцийн газрын Хүний нөөцийн удирдлагын хэлтсийн дарга;

Нарийн бичгийн дарга:

Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга

2. Хөгжлийн богино, дунд, урт хугацааны бодлого, стратеги, хөтөлбөрүүдийн уялдааг сайжруулах зорилгоор бодлогын баримт бичгийг төлөвлөх, тэдгээрт зарцуулах зардлыг төсөвлөх, тайлагнах үйл ажиллагааг нэгдсэн бодлогоор хөгжүүлэх асуудлыг судлах, санал боловсруулах чиг үүрэг бүхий дараах Ажлын хэсгүүдийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай:

2.1. Бодлогын баримт бичгийг боловсруулах буюу төлөвлөх үйл ажиллагааг судалж, үр дүнд суурисан төлөвлөлтийн нэгдсэн цахим системийг нэвтрүүлэх асуудлыг судалж, санал танилцуулах чиг үүрэг бүхий Ажлын хэсэг:

Ажлын хэсгийн ахлагч:

Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга

Гишүүд:

Цахим хөгжил, харилцаа холбооны яамны Бодлого төлөвлөлтийн газрын дарга;

Сангийн яамны Төсвийн хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга;

Сангийн яамны Төсвийн зарлагын хэлтсийн дарга;

Ерөнхий сайдын хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан зөвлөх;

Ерөнхий сайдын орон тооны бус зөвлөх;

НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн төслийн зөвлөх (зөвшилцсөнөөр);

НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн төслийн зөвлөх (зөвшилцсөнөөр);

Хөдөө Аж Ахуйн Их Сургуулийн эрдэмтэн нарийн бичгийн дарга (зөвшилцсөнөөр);

Төрийн бүтээмжийн Үндэсний хорооны Ажлын албаны төрийн бодлогын үр дүнгийн шинжилгээ хариуцсан мэргэжилтэн.

Нарийн бичгийн дарга:

Эдийн засаг, хөгжлийн яамны Хөгжлийн нэгдсэн бодлогын газрын дарга.

2.2. Бодлогын баримт бичигт тусгагдсан арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг төсөвлөх үйл ажиллагааг судалж, үр дүнд суурилсан төсөвлөлтийн нэгдсэн цахим системийг нэвтрүүлэх боломжийг судалж, санал боловсруулж танилцуулах чиг үүрэг бүхий Ажлын хэсэг:

Ажлын хэсгийн ахлагч:

Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга;

Гишүүд:

Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга;

Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга;

Сангийн яамны Нягтлан бодох бүртгэлийн бодлогын газрын дарга;

Цахим хөгжил, харилцаа холбооны яамны Цахим хөгжлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга;

Эдийн засаг, хөгжлийн яамны Нийгмийн хөгжлийн бодлогын хэлтсийн дарга; Монгол Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны ахлах зөвлөх (зөвшилцсөнөөр);

НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн төслийн зөвлөх (зөвшилцсөнөөр);

НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн төслийн зөвлөх (зөвшилцсөнөөр);

Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн мэргэжилтэн;

Төрийн бүтээмжийн Үндэсний хорооны Ажлын албаны төрийн бодлогын үр дүнгийн шинжилгээ хариуцсан мэргэжилтэн.

Нарийн бичгийн дарга:

Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга.

2.3. Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээ, үр дүн, үр нөлөө түүнийг тайлагнах үйл ажиллагааны цахим системийг уялдуулан сайжруулах боломжийг судалж, санал боловсруулж танилцуулах чиг үүрэг бүхий ажлын хэсэг:

Ажлын хэсгийн ахлагч:

Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын дарга

Гишүүд:

Үндэсний аудитын газрын Гүйцэтгэлнийцлийн аудитын газрын дарга (зөвшилцсөнөөр);

Үндэсний аудитын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга (зөвшилцсөнөөр);

Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын Тандалт судалгааны багийн Ахлах судлаач;

Эдийн засаг, хөгжлийн яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга;

Сангийн яамны Санхүүгийн хяналт, эрсдэлийн удирдлагын газрын дарга;

Цахим хөгжил, харилцаа холбооны яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга;

Эрүүл мэндийн яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын

газрын Нийслэлийн Эрүүл Мэндийн газрын тусlamжийн хяналт-шинжилгээ үнэлгээ хариуцсан ахлах шинжээч;

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Салбарын бодлого зохицуулалтын газрын референт;

НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн төслийн зөвлөх (зөвшилцсөнөөр);

НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн төслийн зөвлөх (зөвшилцсөнөөр);

Удирдлагын академийн Бодлого, улс төр судлалын тэнхимиин ахлах багш;

Төрийн бүтээмжийн Үндэсний хорооны Ажлын албаны төрийн бодлогын үр дүнгийн шинжилгээ хариуцсан мэргэжилтэн.

Нарийн бичгийн дарга:

Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын Үнэлгээ, мониторингийн багийн ахлах референт.


3. Нэгдсэн удирдлагын багийн ажлын удирдамжийг хавсралтаар баталсугай.

4. Хариуцсан чиг үүргийн дагуу асуудлыг судалж, шийдэл бүхий саналаа сар бүр Нэгдсэн удирдлагын багт танилцуулж байхыг Ажлын хэсгийн ахлагч нарт даалгасугай.

5. Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний төсөвлөлт, гүйцэтгэл, хяналт-шинжилгээ, үнэлгээ, тайлагнал, үйл ажиллагаанд үр дүнд сууриссан, нэгдсэн цахим удирдлагыг нэвтрүүлэх саналыг нэгтгэн боловсруулж, явцыг Төрийн бүтээмжийн Үндэсний хорооны хуралдаанд танилцуулахыг Нэгдсэн удирдлагын баг /Ч.Хүрэлбаатар/-т үүрэг болгосугай.

МОНГОЛ УЛСЫН САЙД,  
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ  
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА БӨГӨӨД  
ТӨРИЙН БҮТЭЭМЖИЙН ҮНДЭСНИЙ  
ХОРООНЫ ДАРГА

Д.АМАРБАЯСГАЛАН



## НЭГДСЭН УДИРДЛАГЫН БАГИЙН АЖЛЫН УДИРДАМЖ

Нэг. Зорилго

Нэгдсэн удирдлагын баг нь Монгол Улсад үр дүнд суурилсан нэгдсэн цахим тогтолцоонд шилжүүлэх ажлын хүрээнд хөгжлийн бодлого төлөвлөлт, төсөвлөлт, гүйцэтгэл, хяналт-шинжилгээ, үнэлгээ, тайлагналын үйл ажиллагаанд үр дүнд суурилсан, нэгдсэн цахим удирдлагыг нэвтрүүлэн уялдуулах үүрэг бүхий Ажлын хэсгүүдийг нэгдсэн удирдлага, арга зүйгээр хангаж, үйл ажиллагааг уялдуулан зохион байгуулна.

### Хоёр. Нэгдсэн удирдлагын багийн үндсэн чиг үүрэг

2.1. Монгол Улсын хөгжлийн бодлого төлөвлөлт, төсөвлөлт, гүйцэтгэл, хяналт-шинжилгээ, үнэлгээ, тайлагналын өнөөгийн байдалд цогц дүн шинжилгээ хийх;

2.2. Үр дүнд суурилсан нэгдсэн удирдлагыг нэвтрүүлэх эрх зүйн шинэчлэлийн талаарх дүгнэлт, санал, зөвлөмж боловсруулах;

2.3. Үр дүнд суурилсан нэгдсэн удирдлагын цахим системийн шаардлага боловсруулах, нэвтрүүлэх арга зүйгээр хангах, систем нэвтрүүлэх;

2.4. Үр дүнгийн болон гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийн сан бүрдүүлэх арга зүйгээр хангах;

2.5. Олон улсын сайн туршлага, арга, аргачлалыг нутагшуулан хэрэглэх эсэхийг нягталж хэрэглэх боломжийг тодорхойлох;

2.6. Ажлын хэсэг бүрийг удирдлага, арга зүйгээр хангах, үйл ажиллагааг зохион байгуулах, дэмжлэг үзүүлэх;

2.7. Ажлын хэсэг бүрийн төлөвлөгөөг баталж, төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах;

2.8. Ажлын хэсэг бүрийн ажлын явцын тайлантай танилцах, тулгамдсан асуудлыг шийдвэрлэх;

2.9. Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлт, төсөвлөлт, гүйцэтгэл, хяналт-шинжилгээ, үнэлгээ, тайлагналын уялдаа нийцлийг бүх шатанд хангаж, давхардал, хийдлийг арилгах шийдэл бүхий санал боловсруулах;

2.10.Ажлын хэсэг нь Үр дүнд суурилсан нэгдсэн удирдлагыг нэвтрүүлэх ажлын явцыг сард хоёроос доошгүй удаа тайлагнах;

2.11.Үр дүнд суурилсан нэгдсэн удирдлагыг нэвтрүүлэх ажлыг нэгдсэн удирдлага, арга зүйгээр хангаж, үйл ажиллагааг уялдуулан зохион байгуулах.

---oOo---